

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/05/НА-СТА-ТӨА

ТӨВ АЗЗА ТӨХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компани түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин:	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	20
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АЗЗА	Авто зам засвар арчлалт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.16 № 01/212
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Доор дурдсан **төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно.**", 4.1.19-д "Төв-АЗЗА" ТӨХК гэж заасан байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар тогтоолоор Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 төрлийн нийт 898,850.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 52,432.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг Төв АЗЗА ТӨХК-д балансаас балансад шилжүүлж, Хөшгийн хөндийн хурдны замын засвар, арчилгааны ажлыг Төв АЗЗА ТӨХК аар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэн, хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 4 дүгээр тогтоолоор Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж, тайлант оны цэвэр ашгийн төлөвлөгөөг 41,515.4 мянган төгрөгөөр баталснаас 47,818.5 мянган төгрөг буюу 115.2 хувийн биелэлттэй байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь 2022 онд байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээнд тусгагдсан 34 үүргийн биелэлтийг 100.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	28,032,365.18	153,679,887.72
1.1.2	Дансны авлага	314,788,002.40	112,382,511.40
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	-	23,410,193.32
1.1.6	Бараа материал	131,374,972.20	135,053,592.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	16,116,117.00	7,757,919.95
1.1.10	Дуусаагүй үйлдвэрлэл	328,543,252.72	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	818,854,709.49	432,284,105.28
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	632,927,469.77	1,346,619,905.47
1.2.2	Биет бус хөрөнгө	556,913,000.00	556,913,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,189,840,469.77	1,903,532,905.47
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,008,695,179.26	2,335,817,010.75
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	451,187,278.18	-
2.1.1.3	Татварын өр	84,285,860.17	2,522,003.50
2.1.1.4	НДШ - ийн өглөг	17,012,648.81	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	552,485,787.16	2,522,003.50
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	552,485,787.16	2,522,003.50
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	893,549,171.16	1,739,966,254.54
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- Хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	759,175,381.32	759,175,381.32
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	556,913,000.00	556,913,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(753,428,160.37)	(722,759,628.60)
2.3.10		-	-
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,456,209,392.11	2,333,295,007.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,008,695,179.26	2,335,817,010.75

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
3	Борлуулалтын орлого (цэвэр)	2,009,534,755.91	3,337,362,816.46
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,802,888,800.79	3,103,757,274.60
3	Нийт ашиг (алдагдал)	206,645,955.12	233,605,541.86
4	Түрээсийн орлого	25,209,090.91	24,600,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	193,499,348.91	204,881,539.89
11	Санхүүгийн зардал	198,470.00	192,300.00
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	38,157,227.12	53,131,701.97
19	Орлогын татварын зардал	3,815,722.71	5,313,170.20
20	Татварын дараах ашиг (алдагдал)	34,341,504.41	47,818,531.76
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	34,341,504.41	47,818,531.76
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	34,341,504.41	47,818,531.76
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2020 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	893,549,171.16	759,175,381.32	556,913,000.00	(753,428,160.37)	1,456,209,392.11
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	893,549,171.16	759,175,381.32	556,913,000.00	(753,428,160.37)	1,456,209,392.11
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,739,966,254.54	759,175,381.32	556,913,000.00	(770,578,160.37)	2,285,476,475.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	47,818,531.77	47,818,531.77
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	17,150,000.00	17,150,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	1,739,966,254.54	759,175,381.32	556,913,000.00	(722,759,628.61)	2,333,295,007.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,850,736,551.25	3,821,525,468.60
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,732,923,460.00	3,706,358,857.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	47,957,660.37	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	69,855,430.88	115,166,611.60
1.2	Мөнгөн зарлага (-)	1,918,643,364.52	3,561,945,545.09
1.2.1	Ажиллагчдад төлсөн	433,651,378.00	571,834,304.10
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	151,810,710.71	192,481,612.37
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	512,184,862.00	1,490,409,500.18
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	24,863,889.46	74,879,480.12
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	227,109,166.00	713,706,911.97
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	407,280,464.35	270,812,259.35
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,905,676.00	3,982,578.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	157,837,218.00	243,838,899.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(67,906,813.27)	259,579,923.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	116,782,400.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	116,782,400.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(116,782,400.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	867,160.00	17,150,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	867,160.00	17,150,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(867,160.00)	(17,150,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(68,773,973.27)	125,647,523.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	96,806,338.45	28,032,365.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,032,365.18	153,679,887.72

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/ д	Үзүүлэлтүүд	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	2,009,534.8	2,637,180.1	3,337,362.8	700,182.7	126.6
	Улсын чанартай ЗЗА- ын ажил	1,551,409.6	1,836,987.9	2,667,906.8	830,918.9	145.2
	Орон нутгийн чанартай ЗЗА	458,125.2	800,192.2	669,456.1	(130,736.2)	83.7
	Нийт орлого	2,034,743.9	2,661,780.1	3,361,962.8	700,182.7	126.3
	Түрээсийн орлого	25,209.1	24,600.0	24,600.0	-	100.0
2	Нийт зардал	1,996,388.2	2,620,264.7	3,308,830.3	688,565.6	126.3
	Үүнээс: Удирдлагын зардал	193,499.3	304,904.0	204,881.5	(100,022.5)	67.2
3	Татварын өмнөх ашиг	38,157.2	41,515.5	53,131.7	11,616.2	128.0
	Цэвэр ашиг/ алдагдал/	34,341.5	37,363.9	47,818.5	10,454.6)	128.0
4	Төсвийн төлбөр	394,255.6	475,313.9	483,498.5	8,184.6	101.7
	Орлогын татвар	3,815.7	4,472.0	8,061.3	3,589.3	180.3
	НӨАТ	378,380.5	266,178.0	190,197.3	(75,980.7)	71.5
	Газрын төлбөр	2,015.0	2,300.0	2,041.9	(258.2)	88.8
	Хувь хүний орлогын албан татвар	27,402.5	55,407.4	65,464.9	10,057.5	118.2
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	5,751.3	5,750.8	(0.4)	100.0
	НДШ	151,810.7	121,078.6	192,481.6	71,403.1	159.0
	Тээврийн хэрэгслийн татвар, бусад татвар	1,494.5	2,567.5	2,350.7	(216.8)	91.6
	Төрийн өмчийн ноогдол ашиг	867.2	17,559.2	17,150.0	(409.2)	97.7
5	Нийт ажиллагсдын тоо	32	61	34	(27)	55.7
6	Нийт цалингийн сан	485,064.6	835,024.5	695,512.8	(139,511.7)	83.3
7	Нэг ажиллагчийн дундаж цалин	1,263.2	1,140.7	1,704.7	563.9	149.4
8	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	1.0	1.0	1.0	(0.0)	98.9
9	Нийт авлага	314,788.0	150,450.1	135,792.7	(14,657.4)	90.3
	Үүнээс: найдваргүй	-	-	-	-	-
10	Нийт өглөг	552,485.8	240,797.9	2,522.0	(238,275.9)	0.1
	Үүнээс: Богино хугацаат өглөг	552,485.8	240,797.9	-	(240,797.9)	-
11	Хөрөнгө оруулалт	-	157,177.8	81,074.9	(76,102.9)	51.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани түүний үйл ажиллагаа

Төв АЗЗА ТӨХК- үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Төв АЗЗА ТӨХК-ын зорилго нь “Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамуудын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гарсан эвдрэл гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино.

Төв АЗЗА ТӨХК-ийн дүрэм, 2021/02/007 тоот тусгай зөвшөөрөлд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Таван км хүртэл хатуу хучилттай зам барих;
- Хайрган хучилттай зам барих;
- Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл;
- Бүх төрлийн зам гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил;
- Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах;
- Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил, үйлчилгээ эрхлэх ;

3.2 Компанийн гадаад, дотоод орчин:

Төв АЗЗА ТӨХК-ийн үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна. Зам хариуцагч байгууллага нь замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит хуулийн этгээд байна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг ЗТХЯ-ны харьяа байгууллага юм.

Компани 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлдэг.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 390 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн даргыг томилсон байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж, 8 асуудал хэлэлцэн 13 тогтоол баталж, хэрэгжилтийг тооцсон байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороог шинэчлэн томилсон байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ-ийн дарга 1, нарийн бичгийн дарга 1, аудитын хороо 3, нэр дэвшүүлэх хороо 3, цалин урамшууллын хороо 3 нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд 24,037.8 мянган төгрөгийг баталснаас гишүүдийн цалинд 23,360.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай 2022 оны 16 дугаар тогтоол
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.

- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Төв АЗЗА ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын ажиллах журам”-ыг баталж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий нэгжийг 4 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын нэгж нь 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг компанийн гүйцэтгэх удирдлагад танилцуулан баталгаажуулсан байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын шалгалтаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 2,212.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар :

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Төв АЗЗА ТӨХК-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 327,121.8 мянган төгрөгөөр буюу 16,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28,032.3	153,679.9	125,647.6
Авлага	314,788.0	135,792.7	(178,995.3)
Бараа материал	131,375.0	168,598.6	37,223.6
Урьдчилж төлсөн зардал тооцоо	16,116.1	7,757.9	(8,358.2)
Дуусаагүй үйлдвэрлэл	328,543.3	-	(328,543.3)
Үндсэн хөрөнгө	1,189,840.5	1,869,987.9	680,147.4
Нийт хөрөнгө	2,008,695.2	2,335,817.00	327,121.8
Өр төлбөр	552,485.8	2,522.0	(549,963.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,456,209.4	2,333,295.00	877,085.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,008,695.2	2,335,817.00	327,121.8

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оноос өсөж, авлага, дуусаагүй үйлдвэрлэл, өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна.Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 125,647.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст авто замын ажлын санхүүжилтийн үлдэгдлийг шилжүүлж, зарцуулагдаагүй үлдсэн нь нөлөөлсөн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 37,223.6 мянган төгрөгөөр өссөн нь 1,405,300.0 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 1,354,000.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 680,147.4 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй 879,850.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авснаас шалтгаалсан;
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 877,085.6 мянган төгрөгөөр өссөн нь Хурдны замын засвар арчлалттай холбоотойгоор ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар тогтоолоор Зам тээрийн хөгжлийн төв ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4 нэр төрлийн нийт 898,850.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлснийг өмчийн аргаар бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл 178,995.3 мянган төгрөгөөр буурсан нь Төв аймгийн Зуунмод сумын 4 замын уулзварын ажилд “Ялгуусан” ХХК-д туслан гүйцэтгэгчээр ажилласан ажлын хөлсний авлагын үлдэгдлээс 204,462.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан. Тайлант онд нийт 3,207,547.5 мянган төгрөгийн авлагыг бүртгэж, 3,386,542.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 135,792.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлагын үлдэгдлээс Ялгуусан ХХК-аас авах 110,325.6 мянган төгрөгийн, НӨАТ-д 22,762.8 мянган, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 647.3 илүү төлсөн мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.;
- Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэл 8,358.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны урьдчилж шилжүүлсэн тооцооны үлдэгдлийг барагдуулсан нь нөлөөлсөн байна;
- Өр төлбөрийн үлдэгдэл 551,678.8 мянган төгрөгөөр буурсан нь 17,012.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 100,491.5 мянган төгрөгийн татварын, 4

байгууллагад төлөх 397,562.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний өр төлбөрийг төлж барагдуулсан нь нөлөөлсөн байна.

- Эздийн өмч үлдэгдэл 877,085.6 мянган төгрөгөөр өссөн үнэ Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-аас 898,850.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, өөрийн хөрөнгөөр 107,774.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Төв АЗЗА ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,661,780.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,620,264.7 мянган төгрөгөөр, 41,515.5 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 157,177.8 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 3,361,962.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,308,831.1 мянган төгрөгийн зардал гарган, 53,131.7 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,361,962.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 700,182.7 мянган төгрөг буюу 39,9 хувиар давсан нь улсын чанартай зам засвар арчлалтын төлөвлөгөөг 830,918.9 мянган төгрөгөөр буюу 45,2 хувиар давж биелснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 3,308,831.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 688,566.4 мянган төгрөг буюу 26,3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь гүйцэтгэсэн ажлын хэмжээ нэмэгдэж, орлогын төлөвлөгөө 700,182.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн хөрөнгийг өөрийн эх үүсвэрээс 81,074.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 47,818.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,454.6 мянган төгрөгөөр илүү байгаа нь улсын чанартай зам засвар арчлалтын ажлын төлөвлөгөөг 45,2 хувиар давуулан биелүүлж, удирдлагын зардлыг 100,000.0 мянган төгрөгөөр буюу 32,8 хувиар хэмнэж ажилласнаас шалтгаалсан байна.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн 17,150.0 мянган төгрөг, түрээсийн орлогын 40 хувь буюу 7,531.7 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Төв АЗЗА ТӨХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангаа Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,329,579.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 33,295.8 мянган төгрөгөөр тогтоосны 70 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 23,307.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв АЗЗА ТӨХК нь батлагдсан нийт 61 орон тоотой ажиллахаас 34 орон тоотой ажиллаж, цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 161,187.2 мянган, бусад зардлаас 118,165.4 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны болон үнийн өсөлтөөс шалтгаалан түүхий эд материалын зардал 568,893.9 мянган, худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцсоноос элэгдлийн зардал 210,142.5 төгрөгөөр, туслан гүйцэтгэгчийн зардал 82,868.9, мянган, механизм түрээсийн зардал 85,987.7 мянган тээврийн хэрэгслийн түрээсийн зардал 11,200.0 мянган, хөдөлмөр хамгааллын зардал 8,826.0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь зардлын хэтрэлтэд голлон нөлөөлсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 182 мэдээлэл байршуулахаас 167 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 15 мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 58,327.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 57,099.1 мянган төгрөгөөр буюу 1,318.2 мянган төгрөгөөр дутуу, 1 удаагийн 191,980.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 193,000.0 мянган төгрөгөөр буюу 1,019.1 мянган төгрөгөөр илүү байршуулж, 2 удаагийн 70,447.8 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 45,149.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 1 удаагийн 6,111.1 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв АЗЗА ТӨХК-д завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 69,300 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	69,300.0	3	69,300.0	100.0
Нийт дүн	3	69,300.0	3	69,300.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар зардлын тооцоолол, эзэмшигчийн өмчийн талаар гаргасан шийдвэрүүдийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 884,169.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 884,169.7 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Байгууллагын санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүн 1,739,966.3 мянган төгрөг буюу улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс 884,169.7 мянган төгрөгөөр илүү дүнгээр тайлагнагдсаныг;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын дагуу зарласан 17,150.0 мянган төгрөгийн ногдол ашгийг төлөхдөө мөнгөн сууриар бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 6,931.4 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 401.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 6,530.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд 2 ажилтны даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын тайлангийн шимтгэлийн дүнг 160.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлж төлсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Тайлант онд 12 ажилтанд 240.3 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим баримтын дүнтэй тулгахад 5 иргэн, байгууллагын 6,530.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дүгээр сарын 15 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Байгууллагын санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүн 1,739,966.3 мянган төгрөг буюу улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс 884,169.7 мянган төгрөгөөр илүү дүнгээр тайлагнагдсан байна.	1	884,169.7			1	884,169.7	1	884,169.7				
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын дагуу зарласан 17,150.0 мянган төгрөгийн ногдол ашгийг төлөхдөө мөнгөн сууриар бүртгэсэн байна.	1	17,150.0			1	17,150.0	1	17,150.0				
Дүн	1	884,169.7			1	884,169.7	2	901,319.7	-	-	-	-

Төв АЗЗА ТӨХК-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 2 ажилтны даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын тайлангийн шимтгэлийн дүнг 160.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлж төлсөн байна.	1	160.7	1	160.7								
Тайлант онд 12 ажилтанд 240.3 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна.	1	240.3	1	240.3								
Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системийн дүнтэй тулгахад 5 иргэн, байгууллагын 6,530.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.	1	6,530.4					1	6,530.4				
Дүн	3	6,931.4	2	401.0	0	0	1	6530.4	0	0	0	0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 182 мэдээлэл байршуулахаас 167 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 15 мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 58,327.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 57,099.1 мянган төгрөгөөр буюу 1,318.2 мянган төгрөгөөр дутуу, 1 удаагийн 191,980.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 193,000.0 мянган төгрөгөөр буюу 1,019.1 мянган төгрөгөөр илүү байршуулж, 2 удаагийн 70,447.8 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 45,149.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 1 удаагийн 6,111.1 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.	1	124,045.7					1	124,045.7
Дүн							1	124,045.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	124,045.7					1	124,045.7